

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ҮР ДҮНГ ҮНЭЛЖ ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2024.11.11

Сайнцагаан сум

№	Өгсөн зөвлөмж	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5	6	7	8
1	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үр дүнг хагас, бүтэн жилээр тооцож, хэрэгжилтийн хувийг өмнөх оноос нэмэгдүүлэх	Сумдын эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн гүйцэтгэлийг гаргаж хүргүүлэх	Байгууллагын хамааралтай үзүүлэлтийн гүйцэтгэлийн хувь	100	100	Сумдын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн “Газрын дуудлага худалдааны орлогын төвлөрүүлэлт”-ийг сум тус бүрээр гаргадаг. 2024 онд газрын дуудлага худалдааны орлого 200 сая төгрөгийг орон нутагт төвлөрүүлэхээс 11 дүгээр сарын байдлаар 203,7 сая төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлээд байна. Сумдын эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хагас жилийн гүйцэтгэлийг 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 01/300 дугаартай албан бичгээр хүргүүлсэн ба жилийн эцсийн хэрэгжилтийг 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор хүргүүлнэ.	100
		Байгууллагын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн гүйцэтгэлийг гаргаж холбогдох хэлтэст хүргүүлэх	Үзүүлэлтийн гүйцэтгэлийн дундаж хувь	100	100	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн тус байгууллагад холбогдох үзүүлэлтийн хагас жилийн гүйцэтгэлийг 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн	100

						01/300 дугаартай албан бичгээр хүргүүлсэн ба жилийн эцсийн хэрэгжилтийг 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор хүргүүлнэ. 2024 оны 11 дүгээр сарын байдлаар эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн тус байгууллагад холбогдох үзүүлэлтийн дундаж хувь 90 хувьтай байна.	
2	Салбарын тоон үзүүлэлтийн судалгааг нарийвчлан гаргаж, бодлогын баримт бичгийн төлөвлөлтийн суурь судалгаанд ашиглах мэдээллийн сан бүрдүүлэн, цахим хуудсанд байршуулах	Хариуцсан чиг үүргийн хүрээнд салбарын тоон үзүүлэлтийг нарийвчлан гаргаж, бодлогын баримт бичгийн төлөвлөлтийн суурь судалгаанд ашиглах мэдээллийн сан бүрдүүлэх	Зохион байгуулсан арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	-	100	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн Засгийн газарт өгсөн чиглэлийн хүрээнд “Монгол улсын нэгдмэл сан, газар ашиглалт бүртгэл, түүний хяналтын үйл ажиллагааг шалгаж, холбогдох арга хэмжээг хуулийн хүрээнд авч хэрэгжүүлэх ажил”-ын хүрээнд тус аймгийн 15 сумын хэмжээнд 2003-2023 онуудад эрх бүхий этгээдийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд олгосон газрын мэдээлэлд нарийвчилсан хяналт шалгалт хийсэн бөгөөд Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн мэдээлэлтэй тулган шалгаж хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулсан. Дээрх	100

						хяналт шалгалтын хүрээнд 2003-2023 онд аймгийн хэмжээнд олгогдсон газрын нарийвчилсан судалгаа гарч мэдээллийн сан үүссэн. Байгууллагын дарга цаашид үнэн, бодит тоон мэдээллийг бодлогын баримт бичгийн төлөвлөлт, гүйцэтгэл, тайлан мэдээ, судалгаанд ашиглаж байх талаар албан хаагчдад чиглэл өгсөн.	
		Салбарын тоон үзүүлэлтийг иргэд, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах	Ил тод мэдээллэж, сурталчилсан тоо	-	4-өөс дээш	Салбарын 8 төрлийн мэдээллийн тоон үзүүлэлтийг сүүлийн 4 жилийн байдлаар графикаар гаргаж байгууллагын пэйж хуудас, мэдээллийн самбарт байршуулж, иргэдэд ил тод мэдээллэсэн.	100
3	Цахим хуудасны орон нутгийн мэдээллийг өөрийн албан ёсны фэйсбүүк хуудсаараа дамжуулан нийтэд түгээх, пэйж хуудасны хандалтын тоог өмнөх оноос нэмэгдүүлэх	Цахим хуудасны мэдээ мэдээллийг тогтмол шинэчилж, орон нутгийн мэдээллийг байгууллагын албан ёсны фэйсбүүк хуудсаар дамжуулан олон нийтэд түгээх	Аймаг орон нутгийн мэдээллийг түгээсэн тоо	30	30-аас дээш	Байгууллагын цахим хуудас болон facebook хуудас, аймаг орон нутгийн фэйсбүүк хуудсанд байршуулсан салбарын болон орон нутгийн үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээ, мэдээлэл, шторкыг хуваалцаж иргэдэд сурталчилдаг. 2024 оны 11 дүгээр сарын байдлаар 57 удаа аймаг, орон нутгийн мэдээллийг олон нийтэд түгээсэн байна.	100
		Байгууллагын фэйсбүүк хуудасны дагагчийн тоог нэмэгдүүлэх	Нэмэгдсэн дагагчийн тоо	5400	6000	2024 оны 01 дүгээр сард цахим хуудасны дагагч 5400	100

						байсан ба 7045 болж өссөн байна.	
		Байгууллагын пэйж хуудас болон фэйсбүүк хуудсанд байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг ил тод байршуулж, иргэдэд сурталчлах	Шинээр байршуулсан мэдээллийн тоо	60-аас дээш	100-аас дээш	Байгууллагын цахим хуудас / www.dundgovi.gazar.gov.mn/ болон facebook хуудас /Дундговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар/, Дундговь аймгийн нэгдсэн веб хуудас / www.dundgovi.gov.mn/ -нд салбарын болон орон нутгийн үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээ, мэдээлэл, шторкыг байршуулж иргэдэд сурталчилж ажилласан. Хэвлэл мэдээлэл, олон нийтийн цахим сүлжээгээр нийт 250 гаруй мэдээ мэдээллийг байршуулсан.	100
4	Байгууллагын цахим хуудсанд мэдээллийг шалгуур үзүүлэлтийн дагуу бүрэн байршуулж, ил тод байдлын үнэлгээг өмнөх оноос нэмэгдүүлэх	Байгууллагын цахим хуудсанд мэдээллийг шалгуур үзүүлэлтийн дагуу бүрэн байршуулах	Ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын дагуу 98 арга хэмжээнээс тус байгууллагад хамааралтай 79 арга хэмжээг байгууллагын www.dundgovi.gazar.gov.mn цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байршуулж, иргэдэд ил тод,	100

						нээлттэйгээр сурталчилж, мэдээлэл түгээсэн.	
		Шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээлэл байршуулсан эсэхэд дотоод хяналт шалгалт зохион байгуулах	Тавьсан хяналтын тоо	1	1	Тус байгууллагын Мэдээлэл технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн нээлттэй мэдээллийн байдалд 2024 оны 10 дугаар сард дотоод хяналт гүйцэтгэсэн. Дотоод хяналтаар илэрсэн шинэчлэх шаардлагатай 4 мэдээ, тайланг холбогдох албан хаагчид шинэчлэн байршуулсан.	100
		Ил тод байдлын үнэлгээг өмнөх оноос нэмэгдүүлэх арга хэмжээ зохион байгуулж ажиллах	Нэмэгдсэн хувь	90	91	Цахим хөгжил, харилцаа, холбооны яам, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас хийгдсэн нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээгээр 98 хувьтай дүгнэгдэж, улсын хэмжээнд эхний хагас жилээр “Топ-10” байгууллагаар шалгарсан.	100
		“Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын дагуу ил тод мэдээллэх	Журмын хэрэгжилтийн хувь		90-ээс дээш	“Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын нийтэд ил тод мэдээллэх 98 арга хэмжээнээс тус байгууллагад хамааралтай 79 арга хэмжээг байгууллагын сайт болон мэдээ, мэдээллийн самбарт ил тод байршуулсан. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас	100

						хийгдсэн нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээгээр 98 хувьтай дүгнэгдсэн.	
5	Бодлогын баримт бичгийн бодит үр дүнг нэмэгдүүлэх чиглэлээр улирал бүр дүгнэлт хийж, тодорхой арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх	Бодлогын баримт бичгийн удаашралтай заалтуудыг хяналтад авах арга хэмжээг зохион байгуулж ажиллах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	4	4-өөс дээш	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, Барилга, хот байгуулалтын сайдын аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хавсралтаар батлагдсан 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн тус байгууллагын холбогдох заалтуудын хагас жилийн хэрэгжилтийг албан хаагчдад танилцуулсан. Хэрэгжилт удаашралтай байгаа заалтуудыг хяналтад авч, гүйцэтгэлийг эрчимжүүлэх талаар зохион байгуулах арга хэмжээг төлөвлөн үе шаттайгаар хэрэгжүүлэх талаар албан хаагчдад үүрэг чиглэл өгсөн. Хэрэгжилтийн явцыг хамт олны хурлаар 3 удаа хэлэлцүүлж, хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар “Дундговь-Ус” ОНӨААТҮГ-т 3 удаа албан бичиг хүргүүлээд байна.	100

		Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн дундаж хувийг нэмэгдүүлэх	Тухайн жилийн нэмэгдсэн хувь	97,3	97,5	Бодлогын баримт бичгийн гүйцэтгэлийн хагас жилийн дундаж хувь 76 хувьтай байна. - Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн тус байгууллагад холбогдох 16 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь 94 хувь - ЗДҮАХ-ийн тус байгууллагад холбогдох арга хэмжээний хэрэгжилт 100 хувь - Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлт 95 хувь 11 дүгээр сарын байдлаар бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн дундаж хувь 96,3 хувьтай байна.	100
	Дундаж хувь 100						

ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАСАН

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

Э.ЧАГНААДОРЖ

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН

ЗАХИРГАА, ХУУЛИЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Д.БОЛОРЧИМЭГ